



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

Дүүргийн Онцгой комиссын бүрэлдэхүүн,
шуурхай “Ажлын хэсэг”-ийг шинэчлэн
байгуулж, ажиллах журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 23 дугаар зүйлийн 23.1, 23.3, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх хэсэг, 51 дүгээр зүйлийн 51.1, 51.2 дах хэсэг нийслэлийн Засаг даргын 2022 оны А/278 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах үүрэг бүхий дүүргийн Онцгой комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шуурхай Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, Ажиллах журмыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Онцгой комиссын гишүүдийн Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, гамшгийн үед үүрэг гүйцэтгэх бэлэн байдалд хяналт тавьж, нэгдсэн болон мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг дүүргийн Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа), Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Цогбадрах)-т тус тус үүрэг болгосугай.


3. Дүүргийн нутаг дэвсгэрт гарч болзошгүй аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгохтой холбогдон гарах Онцгой комиссын хөрөнгө зардлыг тухайн жилийн Засаг даргын нөөц сангийн зардалд тусгахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Мягмарсүрэн)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн “Онцгой комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай” А/61 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД




Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 02 сарын 14-ны өдрийн 134 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ДҮҮРГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Дүүргийн Засаг дарга
Орлогч дарга:	Онцгой байдлын хэлтсийн дарга Дүүргийн Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	Засаг даргын зөвлөх Засаг даргын Тамгын газрын дарга Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Цэргийн штабын дарга Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Боловсролын хэлтсийн дарга Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Цагдаагийн хэлтсийн дарга Эрүүл мэндийн төвийн дарга Газар зохион байгуулалтын албаны дарга “Багахангай Тохижилт” ОНӨААТҮГ-ын захирал “Илч-орд” ОНӨААТҮГ-ын захирал Ус суваг ашиглалтын товчооны дарга “Налайх” эрчим хүчний Багахангай хэсгийн мастер “Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ-ын захирал Мал эмнэлгийн тасгийн дарга УБТЗ-ын “Багахангай” өртөөний дарга, Нэгдүгээр хорооны Засаг дарга Хоёрдугаар хорооны Засаг дарга Улаан Загалмайн хорооны дарга
Нарийн бичгийн дарга:	Онцгой байдлын хэлтсийн орлогч

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 02 сарын 14 -ны өдрийн 134 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ДҮҮРГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ АЖЛЫН ХЭСЭГ

Нэг. Гамшгийн үед хүч хэрэгслийг нэгтгэн удирдах
шуурхай Ажлын хэсэг:

Дарга:	Дүүргийн Засаг даргын орлогч
Гишүүд:	Онцгой байдлын хэлтсийн дарга Засаг даргын зөвлөх Засаг даргын Тамгын газрын дарга Цагдаагийн хэлтсийн дарга Эрүүл мэндийн төвийн дарга Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Цэргийн штабын дарга Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Боловсролын хэлтсийн дарга УБТЗ-ын “Багахангай” өртөөний дарга Нэгдүгээр хорооны Засаг дарга Хоёрдугаар хорооны Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Онцгой байдлын хэлтсийн орлогч

Хоёр. Дэд бүтэц, газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах
шуурхай Ажлын хэсэг:

Дарга:	Дүүргийн Засаг даргын орлогч
Гишүүд:	Онцгой байдлын хэлтсийн дарга Засаг даргын зөвлөх Засаг даргын Тамгын газрын дарга Цагдаагийн хэлтсийн дарга Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Цэргийн штабын дарга Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Боловсролын хэлтсийн дарга Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Газар зохион байгуулалтын албаны дарга “Багахангай Тохижилт” ОНӨААТҮГ-ын захирал “Илч-орд” ОНӨААТҮГ-ын захирал

Нарийн бичгийн
дарга:

“Багахангай гэрэлтүүлэг, ногоон
байгууламж” ОНӨААТҮГ-ын захирал
Ус суваг ашиглалтын товчооны дарга
“Налайх” эрчим хүчний Багахангай хэсгийн
мастер
УБТЗ-ын “Багахангай” өртөөний дарга
Нэгдүгээр хорооны Засаг дарга
Хоёрдугаар хорооны Засаг дарга
Сууц өмчлөгчдийн холбоодын захирал
Улаан Загалмайн хорооны дарга
Онцгой байдлын хэлтсийн орлогч

Гурав. Үер, ус цаг агаарын аюулт үзэгдлийн үед ажиллах
шуурхай Ажлын хэсэг:

Дарга:
Гишүүд:

Дүүргийн Засаг даргын орлогч
Онцгой байдлын хэлтсийн дарга
Засаг даргын зөвлөх
Засаг даргын Тамгын газрын дарга
Цагдаагийн хэлтсийн дарга
Эрүүл мэндийн төвийн дарга
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
дарга
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн
дарга
Газар зохион байгуулалтын албаны дарга
“Багахангай Тохижилт” ОНӨААТҮГ-ын
захирал
“Илч-орд” ОНӨААТҮГ-ын захирал
Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж”
ОНӨААТҮГ-ын захирал
Ус суваг ашиглалтын товчооны дарга
“Налайх” эрчим хүчний Багахангай хэсгийн
мастер
УБТЗ-ын “Багахангай” өртөөний дарга
Нэгдүгээр хорооны Засаг дарга
Хоёрдугаар хорооны Засаг дарга
Сууц өмчлөгчдийн холбоодын захирал
Онцгой байдлын хэлтсийн орлогч

Нарийн бичгийн
дарга:

Дөрөв. Объектын болон ой хээрийн түймрийн үед ажиллах шуурхай Ажлын хэсэг:

Дарга: Онцгой байдлын хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын дарга
Цагдаагийн хэлтсийн дарга
Эрүүл мэндийн төвийн дарга
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Цэргийн штабын дарга
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Боловсролын хэлтсийн дарга
Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
“Багахангай Тохижилт” ОНӨААТҮГ-ын захирал
“Илч-орд” ОНӨААТҮГ-ын захирал
Ус суваг ашиглалтын товчооны дарга
Налайх” эрчим хүчний Багахангай хэсгийн мастер
УБТЗ-ын “Багахангай” өртөөний дарга
Нэгдүгээр хорооны Засаг дарга
Хоёрдугаар хорооны Засаг дарга
Сууц өмчлөгчдийн холбоодын захирал
Гал түймэр унтраах, аврах 80 дугаар ангийн захирагч

Нарийн бичгийн дарга:

Гал түймрийн улсын хяналтын байцаагч

Тав. Үйлдвэрлэлийн томоохон осол, хөлдөлт, химийн ослын үед ажиллах шуурхай Ажлын хэсэг:

Дарга: Дүүргийн Засаг даргын орлогч
Онцгой байдлын хэлтсийн дарга
Засаг даргын зөвлөх
Засаг даргын Тамгын газрын дарга
Цагдаагийн хэлтсийн дарга
Эрүүл мэндийн төвийн дарга
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
Газар зохион байгуулалтын албаны дарга
“Багахангай Тохижилт” ОНӨААТҮГ-ын захирал
“Илч-орд” ОНӨААТҮГ-ын захирал
Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ-ын захирал
Ус суваг ашиглалтын товчооны дарга
“Налайх” эрчим хүчний Багахангай хэсгийн мастер
УБТЗ-ын “Багахангай” өртөөний дарга
Нэгдүгээр хорооны Засаг дарга
Хоёрдугаар хорооны Засаг дарга


Нарийн бичгийн дарга:

Онцгой байдлын хэлтсийн орлогч

Зургаа. Хүн, мал, амьтны гоц халдварт өвчний үед ажиллах
шуурхай Ажлын хэсэг:

Дарга:	Дүүргийн Засаг даргын орлогч
Гишүүд:	Засаг даргын зөвлөх
	Засаг даргын Тамгын газрын дарга
	Онцгой байдлын хэлтсийн дарга
	Цагдаагийн хэлтсийн дарга
	Эрүүл мэндийн төвийн дарга
	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	Нэгдүгээр хорооны Засаг дарга
	Хоёрдугаар хорооны Засаг дарга
	Хөдөө аж, ахуйн тасгийн дарга
	Мал эмнэлэг үржлийн нэгжийн захирал,
Нарийн бичгийн дарга:	Эрүүл мэндийн төвийн эмч
	Мал эмнэлгийн тасгийн дарга

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны ⁰² сарын ¹⁴ -ны өдрийн ^{1/04} дугаар
захирамжийн гуравдугаархавсралт



ДҮҮРГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг төвлөрүүлэх, хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах, улс, нийслэлийн онцгой комиссоос үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх хууль, гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавихад энэ журмыг дагаж мөрдөнө;

1.2 Онцгой комисс үйл ажиллагаандаа Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно;

1.3 Онцгой комиссын хурлыг дүүргийн Засаг дарга тэргүүлэх бөгөөд, түүний эзгүйд орлогч дарга хуралдуулна. Комиссын хурал гишүүдийн 50-иас доошгүй хувь оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ;

1.4 Онцгой комиссын дэргэд Шуурхай ажлын хэсгүүд ажиллана. Шуурхай ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг дарга батална;

1.5 Дүүргийн хэмжээнд үүссэн нөхцөл байдлын талаар Онцгой комиссын гишүүд санал боловсруулан комиссын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлнэ;

1.6 Онцгой комисс нь хууль тогтоомж, энэ журамд заасан эрх үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж тушаал, албан даалгавар, "Ажлын хэсэг" хурлын тэмдэглэл гаргана.

1.7 Онцгой комисс нь тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.8 Онцгой комиссоос гаргасан шийдвэрийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

1.9 Онцгой комиссын ажлын албаны чиг үүргийг дүүргийн Онцгой байдлын хэлтэс гүйцэтгэнэ. Комиссын өдөр тутмын ажлыг Нарийн бичгийн дарга эрхэлж, Онцгой комиссын Нарийн бичгийн даргыг дүүргийн Онцгой комиссын даргатай зөвшилцсөний үндсэн дээр нийслэлийн Онцгой байдлын газрын дарга томилж чөлөөлнө.

1.10 Онцгой комиссын нарийн бичгийн даргаар онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан ахлах офицерыг, шуурхай ажил хариуцсан албан тушаалтнаар 5-аас доошгүй

нь жил ажилласан офицериЙг томилно. Онцгой комиссын гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.

1.11 Онцгой комиссын нарийн бичгийн дарга нь онцгой комиссын гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

1.12 Онцгой комиссын гишүүдэд Онцгой комиссын даргын шийдвэрээр үнэмлэх олгох бөгөөд гишүүнээс чөлөөлөгдсөн тохиолдолд үнэмлэх бусад зүйлийг онцгой комиссын нарийн бичгийн даргад хураалгана.

Хоёр. Онцгой комиссын эрх, үүрэг

2.1. Онцгой комисс дараах эрхтэй:

2.1.1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын удирдлагад санал, холбогдох бусад байгууллагад үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих;

2.1.2. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны үед хууль тогтоомжид заасны дагуу холбогдох төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, аж ахуйн нэгж, иргэдийг өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан татан оролцуулах;

2.1.3. Холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай судалгаа тайлан, мэдээ, мэдээлэл гаргуулан аван, тайлан мэдээллийг хэлэлцэн шийдвэр гаргаж, биелэлтийг хангуулах;

2.1.4. Гамшгийн голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж, дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;

2.1.5. Гамшгийн аюулаас аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үед онцгой шаардлагатай, хүн хүч, техник хэрэгслийг татан оролцуулах саналаа Улсын онцгой комисст уламжлан Зэвсэгт хүчин болон бусад тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын бие бүрэлдэхүүн, тусгай зориулалтын техник хэрэгслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу дайчлан ажиллуулах;

2.1.6. Өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнд захиргааны шийтгэл ногдуулах саналаа нийслэлийн Онцгой комисс болон эрх бүхий холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх;

2.1.7 Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцож байгаа байгууллага хуулийн этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий шуурхай штаб ажиллуулах, тухайн гамшгийн төрөл, үүссэн нөхцөл байдлаас хамаарч ажиллах журмыг Онцгой комиссын орлогч даргаар батлуулах;

2.1.8 Онцгой комиссын ажлын хэсэг энэ эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах эрхийг хэрэгжүүлнэ;

2.2. Онцгой комисс нь дараахь үүрэгтэй:

2.2.1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний бэлтгэлийг хангуулах ажлыг төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагаар гүйцэтгүүлэх, Засгийн газрын тогтоол, шийдвэр, дүүргийн Засаг даргын захирамж, улс, нийслэлийн онцгой комиссын өгсөн үүргийг хэрэгжүүлэх;

2.2.2. Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

2.2.3. Гамшигтай тэмцэх асуудлаар, олон улсын байгууллага, бусад, аймаг, сумдуудтай хамтран ажиллах, арга туршлагаа харилцан солилцох;

2.2.4. Гамшгийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбогдуулан яам, Засгийн газрын агентлаг, мэргэжлийн байгууллагаас гаргасан санал, дүгнэлт, мэдээллийг хэлэлцэн шийдвэр гаргах;

2.2.5. Гамшиг болсон нутаг дэвсгэр, бүс нутгийн холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийг бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх болон хорио цээрийн дэглэм тогтоох асуудлыг шийдвэрлэх, хэрэгжүүлж байгаа арга хэмжээг нийслэлийн онцгой комисст танилцуулах;

2.2.6. Гамшгийн цагийн нөхцөл байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллага, шинжээчдээр хийлгэх, мөн үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд, гамшгаас хамгаалах албадын мэдээллийг нэгтгэн дүгнэж, удирдлага болон холбогдох албан тушаалтанд танилцуулан бодит мэдээлэл өгөх;

2.2.7. гамшгийн голомтод хүмүүнлэгийн тусламж хүргэх тээвэрлэх явцад хяналт тавих;

2.2.8. гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, нэрвэгдэгсдэд шуурхай тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх ажилд шаардагдах хүн хүч, техник хэрэгслийг зохих журмын дагуу дайчлан гаргах асуудлыг төрийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтантай хамтран шийдвэрлэж зохицуулах, шаардлагатай нэмэгдэл хүн хүч, техник хэрэгсэл дайчлан гаргах санал боловсруулж хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;

2.2.9. Онцгой комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж байх;

2.2.10 Онцгой комиссын ажлын хэсэг энэ үүргээс өөрийн эрх хэсжээний хүрээнд хамаарах эрхийг хэрэгжүүлнэ.

Гурав. Комиссын гишүүний эрх, үүрэг

3.1. Онцгой комиссын гишүүн дараахь эрхтэй:

3.1.1. Дүүргийн гамшгийн нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, зайлшгүй сэргээн босгох арга хэмжээнд ашиглах техник хэрэгслийн бэлэн байдлыг шалгах, шаардлагатай үед

комиссын хуралд асуудал танилцуулан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авах арга хэмжээний талаар санал оруулж шийдвэрлүүлэх;

3.1.2. Гамшгаас хамгаалах тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан захирамж, тушаал, журам, Онцгой комиссын шийдвэр, албан даалгаврын биелэлтийг хангуулахтай холбогдсон асуудлаар дүүргийн нутаг дэвсгэрт өмчийн хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр байгууллага, аж ахуйн нэгжид нэвтрэх.

3.1.3. Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх, шуурхай хариу арга хэмжээ авах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг хангуулах хувцас хэрэгслээр хангагдах;

3.1.4. Шаардлагатай тохиолдолд гамшгийн голомтод чөлөөтэй нэвтрэх, холбоо зарлан мэдээллийн техник хэрэгслийг дараалал харгалзахгүй ашиглах;

3.1.5. Шуурхай ажлын шаардлагаар авто зам ашигласны төлбөр хураамжгүйгээр зорчих, өмчийн төрөл хэлбэр үл харгалзан бүх төрлийн автомашины зогсоолыг ашиглах;

3.1.6. Онцгой комиссын ажлын хэсгийн гишүүн нь энэ эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах эрхийг хэрэгжүүлнэ.

3.2. Онцгой комиссын гишүүн дараах үүрэгтэй:

3.2.1. Онцгой комиссын хуралд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан өөрийн эрхлэх асуудлыг шийдвэрлүүлэх, гамшгийн голомтод зохих журмын дагуу нэвтэрч, үйл ажиллагааг нь шалгаж, заавар, зөвлөгөө өгөх;

3.2.2. Гамшгаас хамгаалах тухай хууль түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан захирамж, тогтоол, тушаал, журам, ажлын хэсгийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хянаж шалгах;

3.2.3. Аж ахуйн нэгж, байгууллагын ажлыг шалгах, заавар, зөвлөгөө өгөх, санал, хүсэлтийг газар дээр нь шийдвэрлэх, дээд шатны байгууллагад танилцуулах;

3.2.4. Хувийн бэлтгэл бэлэн байдлаа хангах, холбоо барих боломжийг байнга бүрдүүлэх;

3.2.5. Онцгой комиссын ажлын хэсэг нь энэ үүргээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах үүргийг хэрэгжүүлнэ.

Дөрөв. Онцгой комиссын зардал.

4.1. Дүүргийн нутаг дэвсгэрт, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэнэ;

4.2. Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс давсан хохирол учирсан, эсхүл хуульд заасан тохиолдолд гамшгаас хамгаалах зардлыг холбогдох төсөв, тооцооны хамт Нийслэлийн Онцгой комисст хандан шийдвэрлүүлнэ;

4.3. Байгууллагууд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан санхүүгийн тайланг дүүргийн Онцгой комиссын ажлын алба /Онцгой байдлын хэлтэс/ тухай бүх гаргаж, Засаг даргын Тамын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст тооцоо нийлнэ;

Тав. Хариуцлага.

5.1. Онцгой комиссын гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хурал тасалбал Онцгой комиссын даргын шийдвэрээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцно;

5.3. Онцгой комиссын гишүүн нь албан үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зургаа. Бусад

6.1. Онцгой комисс ажлын тайлангаа жил бүрийн 12 дугаар сард багтаан Нийслэлийн онцгой комисст танилцуулна.